



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2025 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/549

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийг үндэслэн  
ТУШААХ нь:

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн  
2025-2028 оны стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах  
зардлыг жил бүрийн төсөвт тусган, чиг үүргийн дагуу зохион байгуулж ажиллахыг  
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн захирал  
(Б.Батхүү)-д үүрэг болгосугай.

3.Стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард  
багтаан Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж байхыг захирал (Б.Батхүү)-д  
даалгасугай.

САЙД  Ж.ЭНХБАЯР

1301012411



# **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ХУГАЦАА: 2025 -2028 ОН**

**Улаанбаатар хот  
2025 он**

## СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Орчны шинжилгээ
6. Стратегийн зорилго
7. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн стратеги төлөвлөгөө /2025-2028 он/
8. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төв (цаашид Судалгаа, хөгжлийн төв гэх) нь салбарын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа, лаборатори, туршилт, инкубаци, шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, дамжуулах, сурталчлах, мэдээ, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй улсын төсөвт үйлдвэрийн газар 2020 онд Засгийн газрын 93 дугаар тогтоолоор байгуулагдсан.

Судалгаа, хөгжлийн төв нь 50 жилийн түүхтэй “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 24 жилийн түүхтэй “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрыг нэгтгэх замаар байгуулагдсан. Уг тогтоолоор Судалгаа, хөгжлийн төвийн дүрмийг баталж, үйл ажиллагааны зорилго, чиглэлийг доорх байдлаар тодорхойлсон. Үүнд:

Эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, технологи, эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтын ажлыг гүйцэтгэх, шинжлэх ухаан технологийн болон инновацийн төсөл хэрэгжүүлэх;

Инноваци, технологи дамжуулах: Шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, гарааны бизнесийг хөгжүүлэх инкубаторийн үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ, мэдээ мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах;

Хамтын ажиллагаа: Үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулж гадаад орны ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтын ажиллагааг тогтоох, өргөжүүлэх, албан хаагчдыг чадавхижуулах, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэр аж ахуйн нэгж, аж ахуй эрхлэгчидтэй хамтран ажиллах;

Арьс ширний сорилт шинжилгээний төв лабораторийн үйлчилгээ: Арьс ширний төв лабораторийг MNS ISO/IEC 170 25:2018 стандартын хүрээнд цаашид Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний сорилт шинжилгээний лаборатори болгон өргөжүүлэн нээлттэй зарчимд тулгуурласан үйл ажиллагааг явуулах боломж бүрдүүлэх, дотоодын болон экспортын бүтээгдэхүүнд чанарын баталгаажуулалт хийх;

Мэдлэг, мэдээлэл түгээх: Салбарын яамны захиалгаар хэрэгжүүлсэн шинжлэх ухаан технологи, инноваци болон цөм технологийн төслийн үр дүн, төслийн үр дүнгээр бий болсон оюуны өмчийн баталгаажилт хийгдсэн бүтээгдэхүүн, технологи, арга аргачлалын нэгдсэн цахим мэдээллийн санг үүсгэн хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлэх.

## ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатын шинжилгээгээр Судалгаа, хөгжлийн төвд хууль, тогтоомжоор олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээнд алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилтыг тодорхойлно.

Хүснэгт 1. Судалгаа, хөгжлийн төвийн мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөх хуулийн тоо	27	
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	15
	Нийтлэг мөрдөх хуулийн тоо	12
Ерөнхий чиг үүрэг-1: Эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт		

Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Салбарын судалгаа, туршилт хийх;	Суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх;	ХХААХҮЯ, БШУЯ,
	Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх;	
	Инновацийн төсөл хэрэгжүүлэх;	
	Дэвшилтэт технологийн судалгаа, туршилт хийх;	
Арьс ширний макро лабораторийн судалгаа, туршилт;		
ҮЧҮ-2: Технологийн түвшний үнэлгээ хийх;	Арьс шир, ноос, ноолуур, хүнсний үйлдвэрүүдийн технологийн түвшний судалгаа хийх.	Салбарын боловсруулах үйлдвэрүүд, зөвлөхүүд
Ерөнхий чиг үүрэг-2: Инноваци, технологи дамжуулах		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, инноваци бий болгох;	Хөдөө аж ахуйн мэргэшсэн зөвлөхүүдийг бэлтгэх, зэрэглэл тогтоож, зөвлөх үйлчилгээний сүлжээ байгуулах, тариаланчдад мэдлэг түгээх арга хэмжээ зохион байгуулах;	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гинжин хэлхээнд оролцогч талууд
	Дэвшилтэт технологийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах;	
	Технологи, тоног төхөөрөмжийн туршилт хийх;	
ҮЧҮ-2: Салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах;	Цахим, танхим, талбайн, практик сургалт зохион байгуулах; Инкубаторын үйлчилгээ үзүүлэх	
ҮЧҮ-3: Мэдээллийн сан байгуулах;	Үйлдвэрлэл эрхлэгчдийг зөвлөгөө, мэдээллээр хангах.	
Ерөнхий чиг үүрэг-3: Арьс ширний сорилт, шинжилгээний төв лабораторийн үйлчилгээ		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Бүтээгдэхүүн үйлчилгээний чанарын баталгаажуулалт;	Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн дээжинд сорьц, шинжилгээ хийх;	Стандарт хэмжилзүйн газар, үйлдвэр, аж ахуйн нэгжүүд
ҮЧҮ-2: Арьс ширэн бүтээгдэхүүний стандартчилал;	Үндэсний техникийн шаардлагын стандарт боловсруулах, туршилт, шинжилгээ хийх, батлуулах;	Стандарт хэмжилзүйн газар, олон улсын итгэмжлэгдсэн лабораториуд
	Шинжилгээний аргын стандарт боловсруулах, туршилт, шинжилгээ хийх, батлуулах;	
ҮЧҮ-3: Арьс ширний салбарын мэргэжилтэй ажилтны ур чадварыг дээшлүүлэх чадамжийн сургалт зохион байгуулах;	Чадамжийн сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулах, тайланганах.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, их дээд сургуулийн оюутнууд

## ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Шинжлэх ухааны ололтыг таньд хүргэнэ.

### ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны ололтоор түүчээлэн дэлхийн энтэй хөгжүүлэхэд оршино.

### ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Судалгаа, хөгжлийн төв нь салбарын хөгжлийн төв болон төлөвших боломжтойг орчны шинжилгээ харуулж байна.

Хүснэгт 2. Судалгаа, хөгжлийн төвийн SWOT шинжилгээ

Дотоод орчин	
<p><b>Давуу тал</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Засгийн газрын тогтоолоор батлагдсан төвийн статус, бүтэц;</li><li>- Арьс ширний сорилт шинжилгээний итгэмжлэгдсэн лаборатори;</li><li>- Арьс ширний туршилт үйлдвэрлэлийн цех;</li><li>- Салбартаа танигдсан судлаачид, зөвлөх инженерүүд, эрдэмтэн зөвлөхүүд;</li><li>- Төр болон эрдэм шинжилгээний байгууллага, төсөл хөтөлбөрүүд, үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагаа, сүлжээ, туршлага;</li><li>- Үйлдвэрлэл, туршилт, сургалт, оффисын зориулалтын байр;</li><li>- Сургалт, судалгаа, туршилт, үйлдвэрлэлийн загвар аж ахуйн бааз суурь;</li><li>- Мэргэшүүлэх сургалт зохион байгуулах туршлага, сургалтын эрх, цахим сургалтын платформ;</li><li>- Шинжлэх ухаан технологи, инновацийн төслүүдийн үр дүн, оюуны бүтээлүүд.</li></ul>	<p><b>Сул тал</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Төв лаборатори салбарын хэмжээнд төрөлжөөгүй;</li><li>- Судлаачид, мэргэжилтнүүдийн тоо цөөн;</li><li>- Эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтанд шаардагдах төсөв хангалтгүй;</li><li>- Судлаачид, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх шаардлагатай;</li><li>- Сургалт, судалгаа, туршилт, үйлдвэрлэлийн загвар аж ахуйг бэхжүүлэх шаардлагатай.</li></ul>
Гадаад орчин	
<p><b>Боломж</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Судалгаанд суурилсан салбарын хөгжил, инноваци бий болгох орон зай, эрэлт;</li><li>- Даяаршлын нөлөөгөөр бий болж буй мэдээ мэдээллийн хүртээмжтэй байдал;</li><li>- Мэдээллийн технологийн давуу талуудыг ашиглах боломж;</li><li>- Албан хаагчдыг чадавхижуулах боломж;</li><li>- Хамтран ажилладаг төсөл, хөтөлбөрүүдийн дэмжлэг;</li><li>- Зорилтот зах зээлд байгалийн гаралтай бүтээгдэхүүний брэнд хөгжүүлж худалдаалах боломж;</li><li>- Органик бүтээгдэхүүн хэрэглэх хөгжингүй орнуудын эрэлт, хэрэгцээ.</li></ul>	<p><b>Эрсдэл</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн орчин сул;</li><li>- Улс төр, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал;</li><li>- Бэлчээрийн даац хэтэрсэн, малаас авах ашиг шим бага, түүхий эдийн чанар муу;</li><li>- Хөрсний үржил шим муу, нэгж талбайн гарц муу;</li><li>- Түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бүрдээгүй;</li><li>- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл байгалийн гамшигт өртөх эрсдэл өндөр;</li><li>- Түүхий эдийн үнийн тогтворгүй байдал;</li><li>- Валютын ханшийн тогтворгүй байдал;</li><li>- Малын халдварт өвчин;</li><li>- Байгаль орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгаруулалт.</li></ul>

### Судалгаа, хөгжлийн төвийн үйл ажиллагаанд баримтлах зарчим:

Судалгаа, хөгжлийн төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлана. Үүнд:

- Байгаль орчинд ээлтэй байдлыг хангах;
- Эдийн засгийн үр ашигтай, тогтвортой үйлдвэрлэл, ногоон эдийн засгийг хөгжүүлэх;
- Оюуны өмчийг дээдлэх;
- Үнэт зүйлс.

Судалгаа, хөгжлийн төвийн удирдлага, албан хаагч бүр дараахь үнэт зүйлсийг эрхэмлэн, дагаж мөрдөнө. Үүнд:

- “Манлайлал” – Мэдлэг, технологи дамжуулах үйлчилгээг Олон улсын жишигт нийцүүлэн эрхэлж, салбарын бусад оролцогчдод үлгэрлэх;
- “Харилцан хүндлэлд тулгуурласан нээлттэй харилцаа” – Харилцагч, хамтран ажиллагч байгууллага, иргэн, аж ахуйн нэгж бүрт хүндэтгэлтэй хандаж, харилцан ашигтай хэлбэрээр хамтран ажиллах;
- “Соёл, уламжлал” – Хөдөө орон нутагт шинэ мэдлэг түгээн дэвшилтэт технологи нэвтрүүлэхдээ үндэсний соёл, өв уламжлалд хүндэтгэлтэй хандах;
- “Ёс зүй” – Албан хаагчид, зөвлөхүүд нь хувь хүний болон мэргэжлийн ёс зүйг дээдлэн, хариуцсан ажил үүргээ үнэнчээр нэр төртэй биелүүлнэ;
- “Мерит” – Мэдлэг, ур чадвар, бүтээлч байдал, шинэ санааг үнэлэн, хөхүүлэн дэмжиж, урамшуулах.

### **ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО**

Судалгаа, хөгжлийн төв нь салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлснээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, инкубаторийн үйлчилгээгээр гарааны бизнесийг хөгжүүлэх зорилготой. Зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

**Зорилт 1.** Хариуцлагатай, бүтээмж өндөртэй мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх судалгаа, туршилт, нэвтрүүлэлт;

**Зорилт 2.** Газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, хүнсний ногоо дотоодын үйлдвэрлэлээр хангахад чиглэсэн судалгаа, туршилт, нэвтрүүлэлт;

**Зорилт 3.** Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, мөшгөх тогтолцооны цахим санг хөгжүүлэх, боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих судалгаа, туршилт, нэвтрүүлэлт;

**Зорилт 4.** Итгэмжлэгдсэн лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцоонд нэгтгэн, мэдээллийн нэгдсэн санг бий болгож, лабораторийн хүний нөөцийг чадавхжуулж, хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн лабораторийг хөгжүүлэх;

**Зорилт 5.** Судалгаа хөгжлийн төвийн чадамжийг дээшлүүлэх.

**Долоо. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал**

Салбарын бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн судалгаа, туршилт, инновацийн үйл ажиллагааг зохион байгуулахад ХХААХҮ-ийн яамны холбогдох газар хэлтэс, агентлагууд, яамны харъяа байгууллагууд, Төрийн байгууллагууд, салбарын эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургуулиуд, аймгуудын засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, сумдын засаг даргын тамгын газар, үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод, хоршоод, иргэд, хамтран ажилладаг гадаад, дотоод төсөл, хөтөлбөрүүдтэй харилцан уялдаатай ажиллахаар төлөвлөв.

----oOo----